

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ**

2023.12.10

Мандалговь хот

Шийдвэрийн д/д	Заалтын д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	хувь
нэг. МУ-ын хууль					
1	1	Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58	<p>1.2. Жил бүр Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын тодорхой хувийг байгальд ээлтэй, стандарт бүхий ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд зориулах эрх зүйн орчинг бүрдүүлж, холбогдох шийдвэр гаргах</p> <p>Тайлбар: Тайланд хийсэн ХШҮ-ний дагуу энэхүү заалтыг ирүүлэхдээ дараах зүйлийг анхаарна уу: Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл</p>	<p>"Тэрбум" мод үндэсний хөдөлгөөн, "Дундговьо ногооруулъя" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус хөтөлбөрийн хүрээнд аймгийн ИТХурлын тогтоолоор 2023 онд 100.0 сая төгрөг батлуулсан. Хөтөлбөрөөс ногоон байгууламжийн усалгаа арчилгаанд зориулж 1 гүн өрмийн худаг гаргаж, улсын чанартай авто зам дагуу тарьсан модны хашаа хамгаалалтыг (10046 метр урт тороор) шинэчлэн, алимны модны 60 ширхэг суулгац, зүлэг, цэцгийн мандлыг 2800 м2 талбайд тарих зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэж, Мод үржүүлэг, хүлэмжийн аж ахуйн чиглэлээр туршлага судлах, Ховд аймгийн Булган сумын тариаланч Х.Балжинням, С. Ариунбаатар, "Ногоон-Ази" ТББайгууллагатай хамтран "Алимны мод тариалах арга зүйн сургалт", "Мод ногоон байгууламжийн үрсэлгээ, арчилгаа, усалгаа хийх тарих, арчлах сургалтыг 335 хүнд зохион байгуулсан. Улсын төсвийн хөрөнгөөр Сайнцагаан сумын 4-р багийн нутагт 3 га газарт Жимс, жимсгэнийн суулгац үржүүлгийн төвийг байгуулж хамгаалалтын зурваст улиас, хайлаас зэрэг 875 мод, жимс, жимсгэнийн суулгац 7 төрлийн 1500, нийт 2375 ширхэг мод, сөөгийг тарьж дуслын усалгааны системд холбов. Мөн Сайхан-Овоо суманд 5 га, Сайнцагаан суманд 5 га ойн зурвас, Өлзийт суманд 3 га-д ойжуулалт хийж нийт 16 га-д ногоон байгууламжийг нэмэгдүүлэв.</p>	100

		ажиллагаанд зарцуулах чиглэлээр төлөвлөн хэрэгжүүлж буй үйл ажиллагааг тусгах	Улсын төсвийн 326.0 сая, орон нутгийн төсвийн 79.2 сая төгрөгийг зарцуулав.	
2		1.6. Дүүрэг, сумдад ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдэд мод тарих соёлыг сурталчлан түгээж бүх нийтийн үйлс болгох	“Тэрбум” мод үндэсний хөдөлгөөн, “Дундговиногооруулъя” хөтөлбөрийн хүрээнд цэцэрлэгт хүрээлэнг тохижуулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор Сайхан-Овоо сум 5,6 га-д нэмж 5 төрлийн 9370 мод, Дэлгэрцогт сум 2 га-д 5 төрлийн 4000 мод, Сайнцагаан сумын “Аривжих төгөл”-д шинээр 1 га-д 1000 мод, Тагнуулын газрын “Сүлд” төгөлд 1600, Ногоон говь төслөөр 2 га-д 1048 нийт 17018 мод, сөөг тарьж усалгаа арчилгаа хийв. “Мод тарих үндэсний өдөр”-өөр аймгийн хэмжээнд 141 аж ахуйн нэгж байгууллагын 1284 иргэн 99944 мод сөөг тарьж ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэв. Ногоон байгууламжийн үрсэлгээ, арчилгаа, Алимны мод тариалах арга зүй, Төмс хүнсний ногоо, хүлэмжийн аж ахуйн сургалтыг нийт 335 иргэнийг хамруулан хийж иргэдийн экологийн боловсролыг нэмэгдүүлж мод тарих ажлыг сурталчлан мод тарих, ургуулах, арчлах мэдлэгийг түгээн дэлгэрүүллээ. “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”, “Бүх нийтээр мод тарих өдөр”-ийг угтан 05, 10 дугаар сард “Дундговиногооруулъя” үзэсгэлэн худалдаа зохион байгуулж модны тарьц суулгац, мод тарих арчлах багаж хэрэгсэл тоног төхөөрөмж, нарийн ногоо, хүнсний ногооны үр, үрсэлгээ, зүлэгний үр, мандлын цэцгийн үр, үрсэлгээ худалдаалж, мэргэжлийн байгууллагууд 350 орчим иргэнд газар дээр нь зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа. Бүх нийтээр мод тарих хавар, намрын өдрүүдээр “Ой мод” нетфликсийн баримтат киног 2 ерөнхий боловсролын сургууль, 1 сургалтын төвийн дунд, ахлах ангийн 80 сурагчдад үзүүллээ. Бүх нийтээр мод тарих хавар, намрын өдрөөр 10 төрлийн постер 5 төрлийн видео мэдээллийг хийж байгууллагын вэб сайт,	100

				байгууллагын албан ёсны фэйсбүүк хуудсанд байршуулж ажиллалаа.	
--	--	--	--	---	--

	3		<p>1.7. Мод тарьж ургуулахад шаардагдах усны нөөцийг бүрдүүлэх, ялангуяа гадаргын усыг говийн бүс нутагруу шилжүүлэх, хөв цөөрөм байгуулах, усалгааны хэмнэлттэй дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх зэрэг арга хэмжээний төсөв, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлж, зохион байгуулах арга хэмжээ авах</p>	<p>Тайван улсын чийг баригч эко хувингийн туршилтыг Сайнцагаан сумын "Аривжих төгөл"-д 150 модонд хийж 100% ургуулж орчин үеийн техник технологийг нэвтрүүллээ. Дахин боловсруулсан цаасны целлюлозыг ашиглан эко хувин үйлдвэрлэдэг бөгөөд энэхүү эко хувингийн тусламжтайгаар модны суулгацыг нэг сарын турш ус чийгээр бүрэн хангах боломжтой ба 3 долоо хоногт нэг удаа эко хувинг усаар дүүргэхэд хангалттай. Тус хувинг хаягдал цаасаар хийдэг бөгөөд дунджаар 3 жилийн дотор байгальд задарна. Мод тарьж ургуулахад шаардагдах усны нөөцийг бүрдүүлэх зорилгоор ногоон байгууламжийн усалгаанд Дэлгэрхангай сум 2, Өндөршил сум 1, Эрдэнэдалай сум 3, Дэрэн сум 1, нийт гүн өрмийн худаг гаргав. Олон улсын байгууллагын хөрөнгө оруулалтаар Сайнцагаан сумын Арвижих төглийн 3 га, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Сайнцагаан суманд 3 га-д жимс, жимсгэнийн суулгац үржүүлгийн төв, Сайхан-Овоо сумын Хадан хошууны цэцэрлэгт хүрээлэнд 2 га, нийт 8 га-д дуслын усалгааны систем суурилуулж ногоон байгууламжийн усалгааг шийдвэрлэв. Дэлгэрцогт сумын "Бага газрын чулуу" улсын тусгай хамгаалалттай газрын Чулуун эргийн "Дугуй булаг", Баянжаргалан сумын "Оргихын булаг"-ийг түшиглэн 14 м3 хэмжээ бүхий 2 ширхэг хөв цөөрмийг ногоон байгууламжийн усалгаа болон зэрлэг амьтан ундаалах зорилгоор байгуулав. Улсын төсвийн 250.0 сая төгрөг, орон нутгийн 105.0 сая төгрөг, төсөл хөтөлбөр 30.0 сая төгрөг, хувийн хэвшил 20.0 сая төгрөг зарцуулсан.</p>	100
--	---	--	---	--	-----

	4		<p>1.8. Байгалийн бүс, бүслүүрийн хөрс, цаг агаарын онцлогт тохируулан мод тарьж ургуулах арга, орчин үеийн техник технологийг нэвтрүүлж, нэгдсэн зөвлөмжийг боловсруулан хэрэгжүүлэх, хот, суурин газрын ногоон байгууламжийг хот байгуулалтын нэгдсэн төлөвлөлттэй уялдуулан бие даасан салбар болгон хөгжүүлэх</p>	<p>Улсын төсвийн хөрөнгөөр анжистай нүх ухагч Tavorl 504 маркийн трактор, модны нүх ухагч 3 ширхгийг Сум дундын ойн ангид нийлүүлэв. Тус техник, тоног төхөөрөмжөөр орчин үеийн техник технологийг нэвтрүүлж модны нүх, шуудуу ухах зэрэгт ашиглав. "Тэрбум мод үндэсний хөдөлгөөн", "Дундговιο ногооруулъя хөтөлбөр"-ийн хүрээнд Аймгийн ойн менежментийн мастер төлөвлөгөө-2030" төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын 2022 оны 60 дугаар тогтоолоор 5 зорилтын хүрээнд 29 арга хэмжээг батлуулан 96.3 хувьтай хэрэгжүүлэв. "Бүх нийтээр мод тарих өдөр"-ийг угтан 05, 10 дугаар сард модны тарьц суулгац, мод тарих арчлах багаж хэрэгсэл тоног төхөөрөмж, нарийн ногоо, хүнсний ногоо, зүлэг, мандлын цэцгийн үр, үрслэгээний үзэсгэлэн гаргаж 12 төрлийн 3500 ширхэг тарьц суулгац, 24 төрлийн багаж хэрэгсэл тоног төхөөрөмж худалдаалагдаж, 350 орчим иргэн, байгууллагад газар дээр нь мэргэжил арга зүйн зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа. Сумдын тухайн жилийн ГЗБ-ын төлөвлөгөөнд ногоон байгууламжийн зориулалтаар 19 байршилд 475.73 га, мод үржүүлгийн зориулалтаар 2 байршилд 6 га, нийт 481.73 га газрыг тусган батлуулсан. Сайнцагаан сумын 4-р багийн нутагт 3 га газарт Жимс, жимсгэнийн суулгац үржүүлгийн төвийг байгуулж хамгаалалтын зурваст улиас, хайлаас зэрэг 875 мод, жимс, жимсгэнийн суулгац 7 төрлийн 1500, нийт 2375 ширхэг мод, сөөгийг тарьж дуслын усалгааны системд холбож цэнэг усалгаа хийв. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн "Дундговιο ногооруулъя" хөтөлбөрийн хүрээнд "Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр"-өөр 141 аж ахуйн нэгж, байгууллагын 1284 иргэн 99944 мод, сөөгийг тарьж арчилгаа, усалгаа хийж, нийт модны тоо 285529-д хүрч, тарьсан модны талбайн хэмжээ өмнөх жилээс 4,2 хувиар өсөв.</p>	100
--	---	--	---	---	-----

	5		2. Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай.	“Дэлхийн ойн өдөр”-ийг угтан сурагчид, иргэн, аж ахуйн нэгжийн албан хаагчдад зориулсан 5 удаагийн сургалтад 190 иргэн, “Дундговιο ногооруулья” 2 өдрийн үзэсгэлэнг 350 иргэн оролцлоо. ”Бүх нийтээр мод тарих өдөр”-өөр аймгийн хэмжээнд 1284 иргэн мод тарьж, “Ой мод” баримтат киног 2 сургуулийн нийт 60 хүүхдэд үзүүллээ. Хавар, намрын бүх нийтээр мод тарих өдрүүдээр 4 видео контент, 20 зурагт хуудас хийж, байгууллагын вэб сайт, аймгийн вэб сайтад, байгууллагын албан ёсны фэйсбүүк хуудсанд 40 удаагийн мэдээлэл байршуулсан.	100
ҮАБЗ-ийн зөвлөмж					
2	6	Усны нөөцийг хамгаалах, хомсдлоос сэргийлэх, усны чанар, аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай2019-12-31Дугаар 2019_60/40	2.6. УБ хотын цэвэрлэх байгууламжийн шинэчлэлийн ажлыг эрчимжүүлж, гэр хороолол, аймаг сумын төвүүдэд дэвшилтэт технологи бүхий хэсэгчилсэн, зардал багатай ариун цэврийн байгууламжуудын шийдлийг туршин нэвтрүүлж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг сайжруулах, холбогдох стандартыг мөрдүүлэх	Аймгийн хэмжээнд Сайнцагаан, Өлзийт, Эрдэнэдалай, Гурвансайхан зэрэг 4 суманд цэвэрлэх байгууламжтай болсон. Сайхан-овоо, Луус, Дэлгэрцогт сумдад цэвэрлэх байгууламж баригдаж байна. 2023 онд шинээр стандартын шаардлага хангасан нүхэн жорлон, ариун цэврийн байгууламж 109-өөр нэмэгдэж аймгийн хэмжээнд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн тоо 65 байсан нь 174 болсон. Орон нутгийн төсвийн 60.0 сая, хувийн хэвшлийн 150.0 сая төгрөг зарцуулсан	70

	7		2.7. Усны хэмнэлттэй хэрэглээг төлөвлүүлж, ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх зохистой менежментийг явуулах, үйлдвэрлэлийн хаягдал бохир усыг дэвшилтэт технологиор цэвэрлэж дахин ашиглахыг бодлогоор дэмжих	Сайнцагаан суманд хоногт 3000 м3 бохир ус хүлээн авах хүчин чадалтай цэвэрлэх байгууламж болон бусад туслах үйлчилгээний барилга байгууламжийг 2022 онд ашиглалтад оруулсан. Тус цэвэрлэх байгууламж нь бохир усыг 90% цэвэршүүлдэг бөгөөд нян бактерийн шинжилгээнд хамруулж стандартын шаардлагад нийцвэл 2024 онд нийтийн эзэмшлийн зам дагуух мод, ногоон байгууламжийн усалгааг хийхээр төлөвлөн ажиллаж байна. Сайхан-Овоо суманд үйл ажиллагаа явуулдаг Онгийн нууц, Өлзийт суманд үйл ажиллагаа явуулдаг Говь каравансерай жуулчны баазууд, Гурвансайхан суманд ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг “Эрдэнэс силвер ресурс” ХХК баяжуулах I, II үйлдвэрт ашиглах Герман технологийн цэвэршүүлэх байгууламжийг суурилуулан усыг 88% цэвэршүүлж, 9300 м3 усыг ногоон байгууламж, зам талбайн тоосжилт дарахад дахин ашиглав.	100
3	8	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-09-30 Дугаар 2021_03	3.5. Байгаль орчноо хайрлан хамгаалах, зохион амьдрах, монгол зан заншлыг дээдлэх, уур амьсгалын нөлөөллийг бууруулах, ой мод, усны нөөцийг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор экологийн боловсролыг бүх шатны боловсролын байгууллага болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан бүх нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээ авах.	-”Дэлхийн усны өдөр”-ийг тохиолдуулан ""Хүмүүнлэг"" сургуулийн дунд ангийн 35 сурагчдад “Усны хэрэглээ, усаа хэмнэх энгийн аргууд” сургалт зохион байгуулж, усны талаарх мэдлэг сорих асуулт хариултын “quiz day”, Сайнцагаан сумын 1 дүгээр цэцэрлэгийн 103 хүүхдэд ""Дэлхийн усны өдөр""-ийг тохиолдуулан ""Дусал хүүгийн усаа хэмнэх 5 арга” зөвлөмжийг хүргэлээ. -”Эх дэлхийн цаг”-ийг угтан аймгийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 45 сурагчдад “One planet” netflix-ийн байгаль орчны баримтат киног үзүүлээ.15 сум, аймгийн төвийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд “Эх дэлхийн цаг”-т хэрхэн нэгдэх уриалга хүргүүлээ. Тус арга хэмжээнд аймгийн төв талбайд 03 дугаар сарын 25-ны орой гэрлээ унтрааж, лаа асаан Эх дэлхийн цагаар талбайд, цахимаар, гэрээсээ нэгдсэн нийт 300 гаруй иргэд нэгдлээ. -Усны сургалт, зөвлөгөөн 154, уул уурхайн зөвлөгөөнд, 50 иргэн, иргэдийн оролцоо хэлэлцүүлэг 30, Нээлттэй Дундговь форумын аялал жуулчлалын салбарын	100

				<p>хэлэлцүүлэгт 150, уур амьсгалын өөрчлөлт сургалт, хэлэлцүүлэг 64, Эх дэлхийн цаг 300, "Бүх нийтээр мод тарих өдөр"-өөр аймгийн хэмжээнд 791 иргэн, мод, ногоон байгууламжийн чиглэлээр 580 иргэн, хог хаягдлын сургалт 325 иргэнд, аялал жуулчлалын чиглэлээр 4 удаагийн 106 иргэнд, 2 удаагийн нээлттэй хаалгаар 2850, 1 удаагийн өдөрлөгөөр 324, бүх нийтээр мод тарих намрын өдрүүдээр 2 удаагийн кино сургалт 60, туршлага солилцох уулзалт 2 удаа 77, эко сургууль, цэцэрлэг хөтөлбөрийн хүрээнд 2 цэцэрлэг, 1 сургуулийн 30 албан хаагч, Их газрын чулуу хамгаалалтын захиргаатай хамтран 34 иргэн хамрагдаж, нийт байгаль хамгаалах ажил, арга хэмжээнд 6318 иргэн хамрагдсан. -Байгууллагын вэб сайт, аймгийн вэб сайт, байгууллагын албан ёсны олон нийтийн цахим сүлжээ, МОНЦАМЭ агентлагт нийт 805 мэдээлэл оруулснаар, олон нийтийн сүлжээний цахим хандалт 4234 үзэлттэй, вэб сайтын хандалт 407783. Сургалт сурталчилгаанд Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 2.1 сая төгрөгийг зарцуулав.</p>	
хоёр.ЗГ-ын тогтоол					

4	9	Цаг үеийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх тухай 2022-07-05 Дугаар 2022_5	<p>5. Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, аймаг, сумдын Засаг дарга нарт: 1.1. Улаанбаатар хот, аймаг, сумдад гэр хорооллыг хөгжүүлэх бодлогын санал боловсруулах; 1.2. Гэр хороололд сургууль, цэцэрлэг байгуулах судалгаа, төлөвлөлт, хийх, гэр хорооллын иргэдэд түргэн тусламж, гал унтраах зэрэг тусламж үйлчилгээг шуурхайг хүргэх зорилгоор гудамжны орц гарцыг сайжруулах санал боловсруулах; 1.3. Гэр хорооллын хог хаягдал, хөрсний бохирдол, жорлонгийн асуудлыг шийдвэрлэх, ногоон байгууламж барих, төлөвлөгөө, шийдлийг танилцуулах</p>	<p>1.3. 2023 онд шинээр 4 суманд дахивар авах цэг байгуулагдаж, аймгийн хэмжээнд нийт 7 дахивар цуглуулах цэг ажиллаж 81,5 тн энгийн болон аюултай хог хаягдлыг ангилан ялгаж цуглуулав. Нийтийн эдэлбэр газарт ил задгай зөвшөөрөлгүй хаясан хог болон төвлөрсөн хогийн цэгийн Сайнцагаан 4 га, Адаацаг 0,2 га, Говь Угтаал 3 га, Гурвансайхан 36 га, Дэлгэрцогт 2,5 га, Луус 6,8 га, Өлзийт 5 га, Цагаандэлгэр 1 га, Хулд 3 га, Эрдэнэдалай 16 га, нийт 10 сумын 77,5 га талбайг шууж булшилсан. БОАЖСайдын 02 дугаарт албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн нэгдсэн төлөвлөгөөг батлуулан 15 сумдад хүргүүлсэн. Сайнцагаан сумын ангилан ялгах хогийн савгүй Авто засварын 7, банк 4, Хэвлэлийн 2, шатахуун түгээх станц 13, нийт 26 ААНэгж, байгууллагад ангилан ялгах хогийн савтай болох тухай албан бичгийг хүргүүлсэн. Үүнээс Дэрэн 5, Адаацаг 5, Сайхан-овоо 8, Цагаандэлгэр 2, Сайнцагаан 5 ангилан ялгах хогийн сав сумдад нэмэгдсэн. Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Эрүүл мэндийн газар, Стандарт хэмжилзүйн хэлтэстэй хамтран байгальд ээлтэй ариун цэврийн байгууламжийг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор “Айл өрх бүр эко ариун цэврийн байгууламжтай болцгооё” аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулж Сайнцагаан сумын 5 багийн 200 иргэнд Нүхэн жорлонг стандартад нийцүүлэн сайжруулах хэрэгцээ шаардлага, Нүхэн жорлонгийн стандарт, Эко ариун цэврийн байгууламжийн шийдлүүд, ногоон зээлийн талаарх мэдээллийг хүргэсэн. Мөн Сайнцагаан суманд эко жорлонгийн кольцо үйлдвэрлэгч Мягмарсүхтэй хамтран видео контент бэлтгэж байгууллагын цахим хуудас, аймгийн зарын групп, Хашаандаа сайхан амьдаръя зэрэг группүүдэд нийтэлж нийт 3500 хүнд сурталчилсан. Гэр хороололд стандартын шаардлага хангасан 95 жорлон нэмэгдсэн. Стандарт хэмжилзүйн хэлтсийн</p>	100
---	---	--	--	--	-----

				<p>Сорилтын итгэмжлэгдсэн лаборатори нь 2023 онд Сайнцагаан сумын 16 хөрсөнд 31 үзүүлэлтээр нян судлалын шинжилгээ хийснээс 1 үзүүлэлт нь эерэг гарсан дүнтэй байна. Шинжилгээний дүнгийн талаарх мэдээлэл бүхий улсын байцаагийн дүгнэлтийг сумын ЗДТГ-т хүргүүлсэн. УЦУОШТөвөөс Сайнцагаан сумын 11 цэг дээрээс хүнд металлын бохирдлын шинжилгээний дээж авч Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторид явуулахад Дундговь аймгийн хөрсний хяналт шинжилгээний дүн мэдээг хөрсний чанарын MNS 5850:2019 стандарттай харьцуулахад хүнд металлуудын агууламж хүлцэх агууламжаас давсан тохиолдол байхгүй гэсэн дүгнэлт гарсан. Тус аймаг нь 15 сумын ерөнхий төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан ажиллаж байгаа бөгөөд тус төлөвлөгөөнд ногоон байгууламжийн төлөвлөлтийг хийсэн. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн “Дундговио ногооруулъя” хөтөлбөрийг батлуулан жил бүр орон нутгийн төсөвт 100.0 сая төгрөг тусган ажиллаж байна. Энэ онд “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-өөр 141 аж ахуйн нэгж, байгууллагын 1284 иргэн 99944 мод, сөөгийг тарьж арчилгаа, усалгаа хийж, нийт модны тоо 285529-д хүрч, тарьсан модны талбайн хэмжээ өмнөх жилээс 4,2 хувиар өсөв. Улсын төвөв 76.0 сая төгрөг, ОНТ 159.3 сая, Хувийн хэвшил 359 сая, Төсөл хөтөлбөрөөс 10.0 сая төгрөг зарцуулав.</p>	
<p>гурав.УИХ-ын байнгын хорооны тогтоол</p>					

6	11	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ орон нутагт ажилласан талаар 2023-10-04 Дугаар 2023_40	2.49. Дундговь аймгийн нутагт дэвсгэрт идлэг шонхор шувуу барих, гадаад улсад гаргах квотыг цуцлах хүсэлтийг судлан холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Дундговь аймгийн Засаг дарга Ц.Мөнхбат нарт;	Монгол Улсын Засгийн газрын 264 дүгээр тогтоолоор баталсан 2023 онд соёлын зориулалтаар гадаад улсад гаргах идлэг шонхор шувууны тоо хэмжээг баталсны дагуу гадаадын 13 иргэнтэй хамтран ажиллах гэрээ байгуулсан. 2023 оны 8 дугаар сарын 14-өөс 2023 оны 11 дүгээр сарын 15-ны хооронд гэрээний дагуу шонхор барих үйл ажиллагаа явагдаж Адаацаг, Эрдэнэдалай, Цагаандэлгэр, Дэрэн, Дэлгэрцогт сумдаас 11 шонхор барьж, акт үйлдэж, холбогдох төлбөр хураамж сумдын дансанд шилжин орсноор гэрээ дуусгавар болсон. Эрдэнэдалай суманд 2 шонхор шувууг барьсан боловч орон нутгийн иргэдтэй үл ойлголцлоос шалтгаалж барьсан 2 шонхор шувууг тавьж, тухайн суманд шонхор шувуу барих үйл ажиллагааг зогсоосон.	100
дөрөв.ЗГ-ын албан даалгавар					

7	12	Цаг үеийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх тухай 2022-07-05 Дугаар 2022_5	1.3. Гэр хорооллын хог хаягдал, хөрсний бохирдол, жорлонгийн асуудлыг шийдвэрлэх, ногоон байгууламж барих, төлөвлөгөө, шийдлийг танилцуулах.	2023 онд шинээр 4 суманд дахивар авах цэг байгуулагдаж, аймгийн хэмжээнд нийт 7 дахивар цуглуулах цэг ажиллаж 81,5 тн энгийн болон аюултай хог хаягдлыг ангилан ялгаж цуглуулав. Нийтийн эдэлбэр газарт ил задгай зөвшөөрөлгүй асгасан хог болон төвлөрсөн хогийн цэгийн Сайнцагаан 4 га, Адаацаг 0,2 га, Говь Угтаал 3 га, Гурвансайхан 36 га, Дэлгэрцогт 2,5 га, Луус 6,8 га, Өлзийт 5 га, Цагаандэлгэр 1 га, Хулд 3 га, Эрдэнэдалай 16 га, нийт 10 сумын 77,5 га талбайг шууж булшилсан. БОАЖСайдын 02 дугаарт албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн нэгдсэн төлөвлөгөөг батлуулан 15 сумдад хүргүүлсэн. Сайнцагаан сумын ангилан ялгах хогийн савгүй Авто засварын 7, банк 4, Хэвлэлийн 2, шатахуун түгээх станц 13, нийт 26 ААНэгж, байгууллагад ангилан ялгах хогийн савтай болох тухай албан бичгийг хүргүүлсэн. Сумдад Дэрэн 5, Адаацаг 5, Сайхан-овоо 8, Цагаандэлгэр 2, Сайнцагаан 5 ангилан ялгах хогийн сав нэмэгдсэн. Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Эрүүл мэндийн газар, Стандарт хэмжилзүйн хэлтэстэй хамтран байгальд ээлтэй ариун цэврийн байгууламжийг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор “Айл өрх бүр эко ариун цэврийн байгууламжтай болцгооё” аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулж Сайнцагаан сумын 5 багийн 200 иргэнд Нүхэн жорлонг стандартад нийцүүлэн сайжруулах хэрэгцээ шаардлага, Нүхэн жорлонгийн стандарт, Эко ариун цэврийн байгууламжийн шийдлүүд, ногоон зээлийн талаарх мэдээллийг хүргэсэн. Мөн Сайнцагаан суманд эко жорлонгийн кольцо үйлдвэрлэгч Мягмарсүхтэй хамтран видео контент бэлтгэж байгууллагын цахим хуудас, аймгийн зарын групп, Хашаандаа сайхан амьдаръя зэрэг группүүдэд нийтэлж нийт 3500 хүнд сурталчилсан. Гэр хороололд стандартын шаардлага хангасан 95 жорлон нэмэгдсэн. Стандарт хэмжилзүйн хэлтсийн Сорилтын итгэмжлэгдсэн лаборатори нь 2023 онд	100
---	----	--	--	--	-----

				<p>Сайнцагаан сумын 16 хөрсөнд 31 үзүүлэлтээр нян судлалын шинжилгээ хийснээс 1 үзүүлэлт нь эерэг гарсан дүнтэй байна. Шинжилгээний дүнгийн талаарх мэдээлэл бүхий улсын байцаагийн дүгнэлтийг сумын ЗДТГ-т хүргүүлсэн. УЦУОШТөвөөс Сайнцагаан сумын 11 цэг дээрээс хүнд металлын бохирдлын шинжилгээний дээж авч Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторид явуулахад Дундговь аймгийн хөрсний хяналт шинжилгээний дүн мэдээг хөрсний чанарын MNS 5850:2019 стандарттай харьцуулахад хүнд металлуудын агууламж хүлцэх агууламжаас давсан тохиолдол байхгүй гэсэн дүгнэлт гарсан. Тус аймаг нь 15 сумын ерөнхий төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан ажиллаж байгаа бөгөөд тус төлөвлөгөөнд ногоон байгууламжийн төлөвлөлтийг хийсэн. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн “Дундговьо ногооруулъя” хөтөлбөрийг батлуулан жил бүр орон нутгийн төсөвт 100.0 сая төгрөг тусган ажиллаж байна. Энэ онд “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-өөр 141 аж ахуйн нэгж, байгууллагын 1284 иргэн 99944 мод, сөөгийг тарьж арчилгаа, усалгаа хийж, нийт модны тоо 285529-д хүрч, тарьсан модны талбайн хэмжээ өмнөх жилээс 4,2 хувиар өсөв. Улсын төвөв 76.0 сая төгрөг, ОНТ 159.3 сая, Хувийн хэвшил 359 сая, Төсөл хөтөлбөрөөс 10.0 сая төгрөг зарцуулав.</p>	
--	--	--	--	--	--